



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 5/58

Хэрлэн сум

Л.Мэндбаярт сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1, 49 дүгээр зүйлийн 49.3, 37 дугаар зүйлийн 37.1.15 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 1.4, 1.5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөний биелэлтийн тайлан, өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлсэн аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Лхамсүрэнгийн Мэндбаярт сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Мэндбаярт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Ж.Гантулга)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ